

Д.НАЦАГДОРЖИЙН “ЛАМБАГУАЙН НУЛИМС” ЗОХИОЛЫН АНГЛИ ХЭЛЭЭРХ ХОЁР ОРЧУУЛГЫН ЭРГЭЦҮҮЛЭЛ

С.Дугармаа²⁰
М.Нямдолгор²¹

Abstract: *The paper attempts to study the translation of the story by the Mongolian famous writer D.Natsagdorj “Tears of a Venerable Lama”, which was translated by De.Natsagdorj and another version of translation by Charles Bawden.*

The study extracts some cultural specific terms from the story and their corresponding English translation. Also, we tried to compare these two translated versions of the story.

The finding of the study shows that the translation by De.Natsagdorj was shorter and obvious for readers and the translation by Charles Bawden was more detailed which shows the translator’s desire to convey as much genuine Mongolian culture as possible to the western world and keep the exotic flavor of the original text.

Түлхүүр үг: *шашин, өгүүллэг, үгийн утга, хам сэдэв, орчуулгын арга, хошин зохиол*

Оршил

Бид их зохиолч Д.Нацагдоржийн 1930 онд бичсэн “Ламбагуайн нулимс” өгүүллэгийг МУИС-ийн багш, судлаач, орчуулагч Дэмбэрэлийн Нацагдоржийн орчуулга болон Английн нэрт монголч эрдэмтэн Чарльз Баудены орчуулгыг зэрэгцүүлэн судлахыг оролдлоо.

Их зохиолчийн “Ламбагуайн нулимс” өгүүллэг нь хэдийгээр шашин, лам хуврагын сэдвээр бичсэн болов уу гэж бодохоор ч энэ өгүүллэг нь яруу тансаг зохиомжтой, хэл найруулгын хувьд товч ойлгомжтой бөгөөд тансаг яруу гэж олон судлаачид тэмдэглэжээ. Иймээс энэ зохиолыг хэд хэдэн орчуулагч өөр өөрийн онцлогтойгоор орчуулснаас гадна энэ өгүүллэгийг дуурь болгон дуулж байна.

Энэ өгүүллэг нь орчуулагчдын сонирхлыг татах бүтээл учраас манай орчуулагчдаас гадна гадаадын орчуулагчид өөр өөрсдийн онцлогтойгоор орчуулсан байна. Орчуулгад шашны холбогдолтой болон үндэсний онцлог үгсийг орчуулагчид өөр өөрсдийнхөөрөө орчуулжээ.

“Ламбагуайн нулимс” өгүүллэгийн тухай

“Ламбагуайн нулимс” өгүүллэг нь их зохиолчийн үйл ажиллагаа эрчтэй байсан үед бичсэн түүний олон талт уран бүтээлийн нэг бөгөөд шашин шүтлэг, лам нарын үзэл суртлын эсрэг ширүүн тэмцэл хийж, тэднийг шүүмжилж байсан

²⁰ Доктор /Ph.D/, ШУТИС-ийн ГХС-ийн Англи хэлний тэнхим

²¹ Докторант, ШУТИС-ийн ГХС-ийн Англи хэлний тэнхим

1930-аад оны үеийн уран зохиолын үзэл санаа энэ өгүүллэгт тусгагджээ. Их зохиолч энэ үед өөрийн ихэнх томоохон зохиол бүтээлүүдийг бичсэн. Энэ өгүүллэг нь өнөөг хүртэл уран зохиол судлаачдын сонирхлыг татсан хэвээр байна.

Доктор, профессор, зохиолч, судлаач Ш.Цэнд-Аюуш “Д.Нацагдоржийг юу гэж үнэлдэг вэ гэвэл Монгол ардын аман зохиолыг сайн мэддэг, аман зохиолын суурин дээр орчин цагийн уран зохиолыг төлөвшүүлэх, бий болгоход онцгой үүрэг гүйцэтгэсэн. Түүний зохиолууд уран сайхны хувьд нягт сүлжилдсэн бүтээлүүд байдаг. Өгүүллэгээс нь харахад сайхан зохиомжтой, хэл нь баян тансаг. Бидний байнга хэрэглээд байдаг үгийг төдийлөн ойшоодоггүй хүн байсан. Жишээ нь, “Ламбагуайн нулимс” бүтээлд нь Ловон гэвш Гандангаас Цэрэнлхам гээд эмэгтэйг зорьж ирж байгаа тухай гардаг. Үүнийг л гэхэд олон удаа ирдэг, очдог гэж бичсэнгүй. “Жим гаргажээ” гэж бичсэн байдаг. Ловон гэвшийг дүрслэхдээ “Улаан харыг эгнүүлсээр Гандангийн дэнж рүү бууж ирлээ...” гэдэг ч юм уу айхтар дүрсэлсэн байдаг. Мөн Цэрэнлхам хүүхнийг завхай зайдан гэхийн оронд “Тачаангуйн илдийг гүйцэд эзэмшсэн хүн” гэх жишээтэй (Ш.Цэнд-Аюуш, 2016) гэсэн бол энэ зохиолын гол дүрийг их зохиолч Ч.Лодойдамба “Лодон бол үлэмж хүчтэй эмгэнэлт дүр, Д.Нацагдорж Лодонг огт шоолоогүй харин амьдралд тохиолдсон эмгэнэлт явдлыг үзүүлсэн юм” (Ч.Лодойдамба, 1964:11), “Д.Нацагдоржийн энэ зохиол эмгэнэлт зохиол мөн” (Ч.Лодойдамба, 1964:4) гэжээ.

Уг зохиолыг судалсан ОХУ-ын судлаач, эрдэмтэн К.Н.Яцковская “Д.Нацагдорж энэ ламд өөрөө хэрхэн хандаж байгаагаа нэг ч үгээр илрүүлээгүй түүний шинж байдлыг үйл явдлаар нь дамжуулан гаргасан. Тэгсэн атлаа зохиолч Цэрэнлхамыг шууд буйгаа илрүүлэхгүй ч гэсэн түүний хар санаа, биеэ худалддагийг нь, хар тамхи татах дуртайг нь, худал хуурамч, баашилдаг занг нь үзүүлэх боломж бүрийг ашиглан гаргасан байна. Нацагдорж их авьяас билэгт зохиолч болохоороо Цэрэнлхамын өөдгүй муу чанарыг нь уран сайхны илчлэн гаргах аргаар гүн гүнзгий дүрсэлж, магадгүй өөрөө ч хүсээгүй атлаа Лодонг хүндэтгэх сэтгэлийг бий болгосон байж мэдэх юм. Нацагдорж түүний дүрийг энэрэнгүйгээр шийдвэрлэсэн..... Зохиолч Лодонгийн дүрийг бүтээхдээ бүрэлдэн тогтсон бэлэн зан төрхийг нэг нөхцөл байдлаас нөгөөд шилжүүлдэг (бид ийм байдлыг Цэрэнлхамын жишээн дээр үзэх болно) уламжлалыг огоорч сэтгэлзүйн дүрийг бүтээн бий болгохыг зорьсон” (К.Н.Яцковская, 1974:85) гэх зэргээр судлаачид энэ өгүүллэгийг судлан бичсэн байна.

Зохиогчийн “Ламбагуайн нулимс” богино өгүүллэгээс баатрын болон эд юмсын дүрийг үгээр дархлан бүтээдэг их зохиолчийн урлахуйн чадварыг давхар ажиглаж болно. “Ламбагуайн нулимс” өгүүллэгийн дээр эш татсан өгүүлбэрт:

- Орчлонт ертөнцийг хоосон гэж хүрдийг бясалгаж, винайн ёсыг сахисан,
- Уран тачаангуйн хурц илдийг боловсруулахын эрдмийг судалсан,
- Улаан шарыг тунаруулсаар, -цагаан харыг гялбуулсаар,
- Гандангийн наад хур уруу бууж ирмэгц,

- Баруун дамнуурчны шавартай гудамжнаас гарч ирэх нь гэж Лодон, Цэрэнлхам нарыг “эсрэг тохиолдол” сөрөг харьцууллаар Д.Нацагдорж дүрслэн гаргажээ.

Д.Нацагдорж зохиолоо загварт баригдалгүй олон талтайгаар инээдэм, гашуудлыг хослуулан туурвидаг бөгөөд ер нь шог зохиолд инээдэм эмгэнэлийн аяс ч байдаг. Эмгэнэлт зохиолд инээдэм шоглол ч бас байж болдог. Үүнийг зохиолч Д.Намдаг амьдралын ухаанаар зөв ажиглаж “Уг зохиол шоололтын чанартай боловч эмгэнэлтэй билээ. Гэтэл амьдрал гэдэг маань бүхэл бүтэндээ эс боловч тал хувь нь, тал хувь нь эс боловч бяцхан хувь нь эмгэнэлтэй болж ирээд инээдэмтэй нь аргагүй байдаг бус уу. Иймд Нацагдорж түүнийг аргагүй их авьяаст нүдээр ажсанаа зүй ёсоор бичсэн нь бус уу” (Д.Намдаг, 1966:8) гэж өгүүлсэн юм.

Д.Нацагдоржийн уран бүтээл нь Монголын шинэ утга зохиолыг бий болгохын төлөөх эрэл хайгуул байсан бөгөөд тэрээр хувьсгалт шинэ утга зохиолын анхны зохиолчдын нэг гэдгээ зохиол туурвилаараа харуулж байсан. Д.Нацагдорж 1930-аад оноос шашин шүтлэг, лам нарын үзэл суртлын эсрэг ширүүн тэмцэл хийж, тэднийг шүүмжилж байсан энэ үеийн уран зохиолын үзэл санаа нь энэ өгүүллэгт ч бас тусгагджээ. Үүнийг дүрслэхдээ зохиолч сэтгэлзүйн дүр гаргаж “Ламын хоосон чанарын бодлого” л Лодонг ийм арчаагүй байдалд хүргэснийг илрүүлэн гаргасан ажээ.

“Ламбагуайн нулимс” өгүүллэгийн хоёр орчуулга

Бид их зохиолч Д.Нацагдоржийн “Ламбагуайн нулимс” өгүүллэгийг Монголын нэртэй орчуулагчдын нэг, МУИС-ийн багш, судлаач, орчуулагч Дэмбэрэлийн Нацагдорж агсаны орчуулсан бүтээл “Tears of a Venerable Lama” болон Английн нэрт монголч эрдэмтэн Чарльз Бауден (Charles Roskelly Bawden)-ы орчуулга “The Tears of the Reverend Lama”-ыг зэрэгцүүлэн судлахыг оролдлоо. Багш, орчуулагч Дэмбэрэлийн Нацагдоржийн талаар, 1976 онд монголоос англи руу утга зохиол орчуулах тун бэрх боловч хүндтэй үйлсийн шанг татагч, манай улсын үндэсний англи хэлний ууган мэргэжилтнүүдийн нэг, багш, орчуулагч Дэмбэрэлийн Нацагдорж, шинэ үеийн уран зохиолыг үндэслэгч, зохиолч Д.Нацагдоржийн “Ламбагуайн нулимс” (Tears of a Venerable Lama), “Цагаан сар ба хар нулимс” (White month and bitter tears) өгүүллэг, мөн “Эрийн гурван наадам”(Men’s three games) зэрэг зохиолыг орчуулж байсан (Н.Оюун-ундраа, О.Ган-Энх, 2015:116) хэмээн дурсжээ.

Эрдэмтэн, академич Чарльз Бауден Лондоны их сургуулийн Дорно дахин, Африкийн судлалын сургуульд (ДДАСС) олон жил багшаас эхлээд проректор хүртэл албан тушаалд амжилттай ажиллаж байсан. Тэрбээр 1967-1968 онд БНМАУ-д зургаан сар сурсныхаа дараа Лондоны их сургуульд монгол хэл сурах анги нээж, Лондоны их сургуулийг Европ дахь Монгол судлалын томоохон төв болгоход чухал үүрэг гүйцэтгэсэн гавьяатай хүн. Тэрбээр монголын түүх, уран зохиол, эх бичгийн талаар судалгаа хийж “Алтан товч” (1955), “Бигармижид хаан

ба гучин хоёр модон хүний үлгэр” (1962), “Хүрээний Жавзандамба хутагт” (1962), “Монголын шинэхэн түүх” (1968) зэрэг олон бүтээлийг орчуулж, хянан тохиолдуулсан. Германы монголч эрдэмтэн В.Хайссигтай хамтран “Монголын Боржигин овгийн түүх” хэмээх номоо хэвлүүлж, “Монголын эрт ба эдүгээ” (1959), “Сүнс дуудах ёс” (1962), “Дундад улс ба Монгол орны хоорондох харилцааны тухай ажиглалт” (1974) зэрэг өгүүлэл туурвин нийтлүүлсэн байна. Мөн 1963 оноос эхэлсэн “Монгол-англи толь бичиг”-ээ 1995 онд хэвлүүлж, 2003 онд “Монголын эртний уран зохиолын дээж”-ээс орчуулан хэвлүүлжээ (Ж.Бат-Ирээдүй, 2010). Энэ “Mongolian Literature Anthology” буюу “Монголын эртний уран зохиолын дээж” гэсэн 815 хуудас бүхий номоо Kegan Paul Limited, UK хэвлэлийн газарт хэвлүүлсэн бөгөөд тус номдоо монголын түүх, туульс, үлгэр зэрэг уран зохиолын холбогдолтой бүтээлүүдээ гаргажээ. Мөн энд тэрээр өөрийн орчуулсан их зохиолч Д.Нацагдоржийн “Ламбагуайн нулимс” (The Tears of the Reverend Lama) өгүүлийг багтаасан. Тэрээр би энд Монголын орчин үеийн уран зохиол хуучны сэдвээр шинэ чиглэлд хүрэхээр тэмцэж буйг харуулахын тулд өөрийн орчуулсан нэг богино өгүүлийг багтаасан гэжээ (Charles Bawden, 2003:813-815). Энэ өгүүлэл уг номын сүүлийн хэдэн хуудаснаа багтан орсон байсныг бид хайж олон энэ ажилдаа ашигласан.

Уран зохиолын орчуулгад эх бүтээл уран зохиолын ямар төрөл зүйлд хамаарагдаж буйгаас хамааран орчуулгын хэлбэр ялгаатай байдаг. Тухайлбал өгүүллэг, нийтлэл, яруу найраг, жүжиг, хошин зохиол, туульс, дууны үг гэх мэт. ... үргэлжилсэн үгийн зохиолын орчуулга нь үг, нийлэмж үгийг орчуулахаас эхлэхгүй, харин нэг бүтэн санааг (утгыг) хөг аялгын хамт илэрхийлэхээс эхлэх учиртай. Тэр санаа (утга) нь эх зохиолд бүхэл бүтэн хам сэдэв, түүгээр үл барам бүх зохиолын зангидмал утгаар илэрнэ (Р.Гүрбазар, 1996:24).

“Ламбагуайн нулимс” өгүүллэг нь 966 үгтэй. Дэ.Нацагдоржийн орчуулга нь 1416 үгтэй бол, Чарльз Баудены орчуулга нь 1536 үгтэй болжээ. Дэ.Нацагдоржийн орчуулгад орчуулгын орхилт, ерөнхийлөх зэргээр арай богино болсон бол Чарльз Баудены орчуулгыг ажиглахад нэлээд дэлгэрэнгүй болсон нь үгчлэн болон тайлбарлан орчуулах арга түлхүү хэрэглэсэн нь гадаад (баруун)-ын уншигчдад ойлгомжтой болгох гэснээс үүдсэн болов уу гэж үзэж байна.

Үг сонголт, утга найруулгын чухал болохыг эрдэмтэн, зохиолч Ц.Дамдинсүрэн “...үгийг нэмж, хасах гайгүй хэрэг. Утгыг нэмж, хасвал гэмтэй хэрэг. Үг, өгүүлбэрт халдаж болно. Гол утгад халдаж болохгүй” (Ц.Дамдинсүрэн, 1972:72) гэжээ. “Ламбагуайн нулимс” өгүүллэг нь сайхан зохиомжтой, хэл нь баян тансаг бөгөөд энэ нь орчуулгад сайнаар нөлөөлсөн болов уу. Мөн шашны болон ёс заншлын холбогдолтой үг хэллэгийг тайлбарлах аргаар орчуулсан нь дараах жишээнээс ажиглагдлаа.

1. Зуны цагт баруун дамнуурчны таван гудамжны шавар үлэмж, үнэр ханхлах нь үнэхээр түмэн багц хүжсийг шатаавч үл дарагдмаар. Гэвш Лодон ам хамрыг орхимжоороо бөглөн, хүүхний хойноос намс намс алхална. Удалгүй нэг

хувхай цагаан хаалгаар орвол гангийн арьс ширийн шорвог агаар амтагдаж, зулсан үс, ноос салхинд хийсэн дээл хувцсанд наалдана. Д.Н.

1. Greatly worried she begged him again and again to pray over her mother. In the end he yielded to her and started walking **majestically** to her home, following her. He thought that he would receive substantial remuneration, for the girl seemed to be greatly alarmed. **Soon they entered a weather-bitten white gate.** Passing through a narrow corridor between mud houses they went into a dark burrow-like house which was on the right facing east... Дэ.Н.

1. He could not help seeing how upset she was, and thinking he might get a good fee he **followed** the girl towards her house in order to say some prayers. The Bachelor of Divinity Lodon covered his nose with his scarf and stalked along behind the girl. Before long they went through a weather-beaten, white gate. **The acrid stink of skins in the tanning-vats assailed them, and bits of fur and hair flying in the wind stuck to their clothes.** Passing through a narrow way between two tumbledown mud huts, they went into an east-facing cave-like building on the western side. Ch.B.

2. Хажуугаар нь үг хэлэх ба инээн аашлах нь их л бахтай. Хоёр хар нүдээ жирвэгэнүүлэн эргэлдүүлэх бүрд Лодонгийн сэтгэлд бяцхан ширүүн гал ноцон алдана. Д.Н.

2. Apart from that, the girl's ways of speaking and laughing were charming. Every time she **flashed her shining black eyes, a tiny spark almost caught fire** in Father Lodon's mind. The girl already understood this state of affairs. Дэ.Н.

2. She chatted and laughed with him ever so pleasantly. Each time she **flirted with her two black eyes, a fierce little flame sparked and flared** in Lodon's heart. Ch.B.

3...хүүхэн хөнжил дээрээ дотуур хувцсаа тайлж байх нь дэнгийн гэрэлд үнэхээр үзэсгэлэнтэй үзэгдэж, сэтгэлийг хөдөлгөхөд, **ламын хоосон чанарын бодлого** хэдийнээ нөгөө ертөнцөд шилжиж винайн ёс нэгэнт баруун зууд одоод, **тачаангуй гал дүрэлзэн бадрахад** орж хүүхний хамт нойрсов. Д.Н.

3...the girl was undressing and taking off her underclothes; it was an enchanting sight. The lama was very excited; **his lama's dogma of emptiness** was consigned to the other world and the doctrines of the Vinaya had flown back to the Western Zuu. **He was consumed with the fire of lust** and hurriedly entering the room he went to sleep with the girl. Дэ.Н.

3...the girl taking off her underclothes on the blanket. She looked really pretty in the light of the lamp, and it made him excited. **The lama's ideas about the Void** had long since migrated to another world, and the Laws of the Discipline had by now fled to Lhasa. **Up blazed the fire of lust,** and he went in and slept with the girl. Ch.B.

Дэ.Нацагдоржийн орчуулгад ...хар тамхи тасарсан учир, ... гангийн арьс ширийн шорвог агаар амтагдаж, зулсан үс, ноос салхинд хийсэн дээл хувцсанд наалдана. Зуны цагт баруун дамнуурчны таван гудамжны шавар үлэмж, үнэр ханхлах нь үнэхээр түмэн багц хүжийг шатаавч үл дарагдмаар. Гэвч Лодон ам хамрыг орхимжоороо бөглөн ...гэсэн хэсгийг орхигдуулсан нь тухайн үеийн үзэл

суртлын шаардлагаар хасагдсан болов уу гэж таамаглаж байна. Харин Чарльз Баудены орчуулгад эдгээр хэсгийг орчуулсан байна.

Д.Нацагдоржийн энэ өгүүллэгт шашны холбогдолтой болон үндэсний онцлогтой үг хэллэг нэлээд орсон бөгөөд эдгээрийг ямар үгээр буулгасныг зэрэгцүүлэн үзүүлбэл:

| Д.Нацагдоржийн зохиолд | Дэ.Нацагдоржийн орчуулгад | Баудены орчуулгад |
|----------------------------------|---|--|
| гэвш | father lama | Bachelor of divinity |
| гавж | Gabji-degree | degree of Doctor |
| винайн ёсыг сахисан | a master of the vinaya | obeyed the Laws of the Discipline |
| Ламбагуай | Venerable Lama | Your Reverence |
| хурал | rite | service |
| цагаан дарь эх | the White Tara | the Goddess Dar Ekh |
| барьц | remuneration | fee |
| багц хүж | - | packets of incense |
| бяцхан гүнгэрваатай бурхан | a small framed icons of Buddhas | a Buddha-statue in a frame |
| ном уншиж, залбирал даатгал хийх | finished chanting and paying homage to protective spirits | recited the scriptures and recited his prayers |
| гүнгэрваатай бурхан | framed Buddhas | framed statues of Buddhas |
| ламын хоосон чанарын бодлого | his lama's dogma of emptiness | the lama's ideas about the Void |
| хуврагын ёс | holy priesthood vows | religious vows |
| дөрвөн ханатай гэр | four-walled ger | four-section tent |

Эдгээр шашны холбогдолтой болон үндэсний онцлог үг хэллэгийг Дэ.Нацагдорж болон Чарльз Баудены орчуулсан нь ихэвчлэн тайлбарлах аргаар орчуулсан бөгөөд энэ хоёр орчуулагч өөр өөрсдийнхөөрөө үг хэллэгийг сонгон авч хэрэглэсэн байна.

Дүгнэлт

Энэ ажлаараа бид Монголын шинэ үеийн уран зохиолын хамгийн тод төлөөлөгч Д.Нацагдоржийн “Ламбагуайн нулимс” өгүүллэгийг англи хэлээр Монголын багш, орчуулагч Дэ.Нацагдорж ба Их Британийн эрдэмтэн, монгол судлаач Чарльз Бауден нарын орчуулсныг зэрэгцүүлэн ажиглаж үзлээ.

Чарльз Баудены орчуулга нь үг, өгүүлбэр бүрийг нарийвчлан тайлбарлан орчуулсан нь барууны уншигчдад Монголын шашин, лам нарын амьдрал, монгол ахуйг танилцуулахын тулд болов уу гэж үзэж болох юм.

Дэ.Нацагдоржийн орчуулга нь арай богино байгаа нь зарим үг хэллэгийг оновчтой хэрэглэсэн ба зарим үг хэллэгийг хасаж, орхисон ч утгыг нь товч тодорхой ойлгомжтой гаргаж чадсан байна.

Шашны холбогдолтой үндэсний онцлог үг хэллэгийг Дэ.Нацагдорж болон Чарльз Бауден нар ихэвчлэн тайлбарлах аргаар орчуулсан бөгөөд энэ хоёр орчуулагч өөр өөрсдийнхөөрөө үг хэллэгийг сонгон хэрэглэсэн байна.

Энэхүү хоёр орчуулга нэг нь нөгөөгөө хуулбарлаагүй, Монголын уран зохиолын орчуулгын дахин давташгүй чухал бүтээл болжээ.

Номзүй

1. Бат-Ирээдүй Ж.(2010), Британий монгол судлал, монголч эрдэмтэд.
http://iregedui.blogspot.com/2010/02/blog-post_3987.html.
2. Гүрбазар Р.(1996), Орчуулгын онол дадлагын үндэс, УБ.
3. Дамдинсүрэн Ц., *Монголд уран зохиолын орчуулга хөгжсөн нь*, “Орчуулах эрдэм”.УБ. 1972.
4. Лодойдамба Ч.,*Нэгэн гайхамшигт өгүүллэгийн тухай*, “Утга зохиол урлаг”, УБ.1964 №11.
5. Лодойдамба Ч., *Баримт түшиж ярих сайхан*, “Утга зохиол урлаг”, УБ. 1964 №4.
6. Намдаг Д., *Танин мэдэж таниулан мэдүүлэх нь*, “Утга зохиол, урлаг”, УБ. 1966 №8.
7. Оюун-ундраа Н., Ган-Энх О.,*Англи хэлнээ орчуулсан монгол уран зохиолын бүтээлийн тойм*, МУИС –ийн ШУС-ийн ЭШБ, 2015 № 19 (430).
8. *Цэнд-Аюуш Ш.(2016)*, Суут хүмүүс нийгэм, цаг үеийн ямар ч хавчлага дунд хийх юмаа хийгээд буцдаг. <http://time.mn/k0K.html>.
9. Bawden C.R.(2003), *Mongolian Literature Anthology*, 1sted, UK. Kegan Paul Limited.
10. Яцковская К.Н.(1974), *Дашдоржийн Нацагдорж-Жизнь и творчество*, Изд., Наука, Москва.